
“УЛАМЖЛАЛТ ЭМ, ЭМИЙН УРГАМАЛ” КОМПАНИ

НЭГ. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН ТҮҮХ

“Уламжлалт эм, эмийн ургамал” компани нь анх БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 09-р сарын 06-ны өдрийн 305 дугаар тогтоолоор “Эмийн ургамал бэлтгэх контор” нэртэй, 1968 оны 09-р сарын 10-ны өдрөөс орон нутгийн агент салбартайгаар аж ахуйн тооцоотой ажиллахаар байгуулагдсан байна.

Эрүүл мэндийн Яамны сайдын 1990 оны А/151 дугаар тушаалыг үндэслэн “Монгол Эмимпэкс” нэгдлийн ерөнхий захирлын 1990 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 12 дугаар тушаалаар “Эмийн ургамал бэлтгэх контор”-ыг татан буулгаж, Нийслэлийн 28 дугаар эмийн сантай нэгтгэж, тус нэгдлийн харьяанд “Уламжлалт эм, эмийн ургамлын пүүс ” байгуулж, пүүсийн дүрмийг батлан, 1991 оны 01 дүгээр сарын 01-нээс үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн.

Эрүүл мэндийн Яамны сайдын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/182 тоот тушаалаар Нийслэлийн өмчийн харилцааны газрын харьяанд шилжиж “Уламжлалт эм, эмийн ургамал компани” нэртэйгээр Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн газар болон зохион байгуулагдсан.

1968 онд 32000 төгрөгийн үндсэн ба эргэлтийн хөрөнгөтэй, 10 ажилтантай, Монгол орны эмийн ургамлын нөөцийг судлан тогтоох , төлөвлөгөөний дагуу жил бүр экологийн гаралтай цэвэр түүхий эд, ургамал түүж бэлтгэн тухайн үеийн “Эмийн завод”-ыг хангах, гадаад орнуудад экспортлох, зарим ургамлыг тарималжуулах зорилготойгоор анх байгуулагджээ.

Социалист нийгмийн харилцааны үед жилийн болон таван жилийн төлөвлөгөөтэй ажиллаж улсаас өгсөн төлөвлөгөөний дагуу ажиллан төлөвлөгөөт зорилтоо биелүүлж, жилээс жилд үйл ажиллагааны цар хүрээ нь өсөж иржээ.

Зах зээлийн харилцааны үед дэлхий даяар экологийн гаралтай эм бэлдмэл, хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлага улам ихээр өсөхийн хирээр энэ үйлдвэрийн үүрэг роль жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг төр засгаас анхаарч, үйл ажиллагааг нь дэмжиж цаашид хөгжүүлэх бодлого баримтлан “Уламжлалт анагаах ухааны талаар 2015 он хүртэл баримтлах бодлого” боловсруулан гаргасан юм.

Тус компани нь Монгол Улсын Их Хурлын 1999 оны "Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх" тухай 46-р тогтоолыг хэрэгжүүлж, "Уламжлалт анагаах ухааны талаар 2015 он хүртэл баримтлах бодлого", мөн шинээр батлагдсан "Эрүүл мэндийн хууль", "Эмийн үндэсний бодлого", шинэчлэн найруулсан "Эмийн тухай хууль" болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмыг мөрдөн ажиллаж, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Эрүүл мэндийн яамнаас өгсөн үүрэг даалгаврыг удирдлага болгон бизнесийн үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Манай оронд зах зээлийн харилцааны үйл явц жил ирэх тусам өндөр хурдацтай өрнөж, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын ижил төрлийн үйлдвэр компаниуд олноор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа нь зах зээлийн өрсөлдөөнийг улам гүнзгийрүүлэхийн хэрээр манай компани, манай хамт олныг бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж шинээр сэтгэж ихийг бүтээхийг аяндаа шаардаж байгаа бөгөөд бид ч нийгмийн, болон үйлдвэр, ШУ-ны хөгжил дэвшлээс хоцрохгүйг хичээн мэрийн ажиллаж ирлээ.

"Уламжлалт эм, эмийн ургамал компани" нь "Эмийн ургамал бэлтгэх контор" нэртэй үүсэн байгуулагдсан цагаас эхлэн өөрийн орны болон ЗХУ, Энэтхэг, Хятад зэрэг улсуудын тухай тухайн үеийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, техник технологийг хэрэглэж ирсэн ба тэдгээрийг жилээс жилд шинэчлэн өөрчилж улам боловсронгуй болгон сайжруулж, зах зээлийн харилцааны үед Япон, Солонгос, Хятад зэрэг орнуудын үйлдвэрлэлийн техник технологиос үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлж ажиллаж байна.

Мөн өөрийн оронд ургадаг эмийн ургамал, амьтны болон эрдсийн гаралтай түүхий эдийг жил жилд төлөвлөгөөтэйгээр бэлтгэдэгээс гадна Хятад улсын Өвөр монгол, Түвд зэрэг гадаад орноос ургамал, амьтны болон эрдсийн гаралтай түүхий эд, сав баглаа боодол үйлдвэрлэх багаж тоног төхөөрөмжийг худалдан авч үйлдвэрлэлд хэрэглэж байна

Одоогийн байдал: Манай компани 102 сая 262,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө 31 сая 946,9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 15 ажиллагстайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс хойш дээд газрын шийдвэрээр 2-3 удаа байрлах байраа сольсон бөгөөд одоо тухайн үеийн ЗХУ-ын барилгын ажилчдыг байрлуулах түр барилгын зориулалтаар 1965 онд баригдсан 400 м2 талбай бүхий төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усанд холбогдсон 2 давхар байшинд үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн тайлан тэнцэлд **70813,0 мянган** төгрөгийн өртөг бүхий барилга байгууламж, тохижилтын хөрөнгө, **2106,0 мянган** төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгсэл, **29342,9 мянган** төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж тавилга эд хогшил тусгагдсан байгаа боловч барилгаас бусад үндсэн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн ба ихэнх нь хугацааны болон маролын элэгдэлд ороод байна.

Компанийн барилга ашиглалтанд орсноосоо хойш 46 жил болж байгаа бөгөөд одоо Уламжлалт эм ,эмийн үйлдвэрийн барилгад тавигдах ерөнхий шаардлага ММЗ-5524-2005 стандартад тохируулан засвар хийх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд үүнд ойролцоогоор 30,0-35,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа юм.

а/ Хангамж, үйлдвэрлэлт , борлуулалтын талаар: Тус компани өөрийн үйлдвэрийн хэрэгцээг хангахдаа манай оронд ургадаг эмийн ургамал, мал амьтаны гаралтай түүхий эд, эрдэс бодисыг өөрсдийн хүчээр олж бэлтгэхээс гадна иргэд байгууллагатай гэрээ хийж бэлтгүүлэх, гадаад орноос худалдан авах замаар хангаж байна.

Сүүлийн жилүүдэд 100-гаад нэр төрлийн талхан эм, 40 гаруй нэр төрлийн тан,10 гаруй нэр төрлийн үрлэн эм хийж иргэдийн хэрэгцээнд гаргаж , шинээр тархаж байгаа ханиад томуунд европ эмнээс илүү үр дүн үзүүлж байгаа 20-25 нэр төрлийн эмийг шинээр үйлдвэрлэж эмийн сангуудад нийлүүлж байна. Мөн жил бүрийн хавар Байгаль орчны яамны зөвшөөрөлтэйгээр өөрсдийн ажилчдын хүчээр хусны шүүс бэлтгэж эмнэлэг, эмийн сангуудад нийлүүлж ирлээ.

Жилд дунджаар 50,0 мянга шахам ширхэг пачик болон үрлэн эм үйлдвэрлэж 30 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж байна. Түүхий эд, баглаа боодол, багаж хэрэгсэл худалдан авах үнэ ханш жилээс жилд өсөж байгаагаас гадна дулаан цахилгааны үнэ өсөх, ажилчдын цалин хөлсийг нэмэх зэрэг зах

зээлийн бодит шаардлагын үүднээс зардал жилээс жил ирэх тусам өсөж ашиг хуримтлал доривтой нэмэгдэхгүй байна. Гэвч зах зээлийн жилүүдэд манай байгууллага улсын төсвөөс ямар ч санхүүжилт авахгүйгээр үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

б/ Судалгаа шинжилгээ, шинэ бүтээгдэхүүний талаар: Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг "Мамба дацан", "Элэгний эм үйлдвэрлэлийн төв", "Анагаах ухааны корпораци" зэрэг байгууллагуудтай өрсөлдөн монгол эм үйлдвэрлэл болон судалгаа шинжилгээний ажлаа явуулж ирлээ.

Манай компани үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ чанарт анхаарч эмийн түүхий эдээ бэлтгэх стандарт хугацаанд ихээхэн анхаарч Байгаль орчны яамны мэргэжлийн хүмүүстэй өөрийн мэргэжлийн хүмүүсийг хамтран ажиллуулж, ургамлын хөгжлийн үе шат ,түүж бэлтгэх орон зай цаг хугацааны хуанлийг 123 ургамал дээр гаргалаа. Мөн анхан шатны боловсруулалт хийх, хатаах аргачлалын заавар журмын дагуу уламжлалт эмэнд ордог 25 нэрийн ургамлын нөөц, тэдгээрийг бэлтгэж болох хэмжээг шинээр тогтоож, бэлтгэх сэлгээний график гарган түүнийгээ мөрдөн ажиллаж байна.

НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ

Д/д	Нэрийн өөрчлөлт	Он
1	"Эмийн ургамал бэлтгэх контор"	БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 09-р сарын 06-ны 305-р тогтоол
2	"Уламжлалт эм, эмийн ургамлын пүүс "	Эрүүл мэндийн Яамны сайдын 1990 оны А/151 дугаар тушаалыг үндэслэн Монгол Эмимпэкс Нэгдлийн ерөнхий захирлын 1990 оны 12 дугаар сарын 28-ны 12 дугаар тушаалаар
3	"Уламжлалт эм, эмийн ургамал компани"	Эрүүл мэндийн Яамны сайдын 1997 оны 12 дугаар сарын 19-ны А/182 дугаар тушаалаар

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ БИЧСЭН
АРХИВЧ У. ДАВААЖАВ